

**“ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**  
**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 27 өдөр

№: .01

Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН**  
**ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 260,562 ширхэг хувьцаа эзэмшдэг 5 хувьцаа эзэмшигчид биеэр оролцсон нь нийт саналын эрх бүхий хувьцааны 91.7 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 91.7 хувийг эзэмшигчид хуралд оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

**ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА**  **Б.БАТБААТАР**



**“ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН**  
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН**  
**ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 27 өдөр

№: 02

Улаанбаатар хот

**Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай**

Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.8 дах заалт, 72-р зүйл, “Орхон булаг” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн 2013.04.27 – ны өдрийн ээлжит хуралд санал хураалтаар ирүүлсэн санал хураах хуудсыг тоолсон дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Орхон булаг” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцсэн асуудлуудаар санал хураасан дүн дараах байдалтай байгааг хуралд оролцогчдод мэдээлсүгэй:

Үүнд:

1.1 Компанийн 2012 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах асуудлаар:

Зөвшөөрсөн 260,562 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

1.2 “Орхон булаг” ХК-г “Орхон булаг” ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрөх, төсөл батлах

Зөвшөөрсөн 260,562 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

1.3 Компанийн ТУЗ-ийн гишүүдийг шинээр сонгох

Зөвшөөрсөн 0 ширхэг хувьцаа буюу 0%, татгалзсан 260,562 ширхэг хувьцаа буюу 100 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

1.4 Их хэмжээний хэлцэлийг батлах

Зөвшөөрсөн 260,562 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

1.5 “Орхон булаг” ХХК-ийн дүрэмийн шинэчлэсэн найруулгыг батлах

Зөвшөөрсөн 260,562 ширхэг хувьцаа буюу 100 %, татгалзсан 0 ширхэг хувьцаа буюу 0 %, түдгэлзсэн 0 ширхэг хувьцаа буюу 0 % байна.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА



Б.БАТБААТАР

**“ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 27 өдөр

№ 03

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 63-р зүйлийн 63.5 дах заалт, “Орхон булаг” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2012 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсан үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



*Д.Оюунсүрэн*  
Д.ОЮУНСҮРЭН

**“ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 27 өдөр

№: 04

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ГИШҮҮДИЙГ СОНГОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 75-р зүйлийн 75.2-р заалт, 2013 оны 4-р сарын 27 –ний өдрийн тооллогын комиссын ... дугаар тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани нь хэлбэрээ өөрчлөн “Орхон булаг” ХХК болж байгаатай холбогдуулан компанийн хувьцаа эзэмшигчдийн саналаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгохгүй байхаар шийдвэрлэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Д.ОЮУНСҮРЭН



# “ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 сарын 27 өдөр

№: 05

Улаанбаатар хот

## **“ОРХОН БУЛАГ” ХК-г “ОРХОН БУЛАГ” ХХК БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРӨН ТӨСЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62.1.4, 63.8 дах заалтууд, “Орхон булаг” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Орхон булаг” ХК-г “Орхон булаг” ХХК болгон компанийн хэлбэрийг өөрчлөн зохион байгуулсугай.
2. Компанийг ХХК болгон өөрчлөн байгуулах төслийг хавсралтаар баталсугай.
3. Төслийг баталсантай холбогдуулан холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудад хүргүүлэн зөвшөөрөл аван шийдвэрлүүлэхийг компанийн Гүйцэтгэх Захирал /А.Лайханжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГАК  Д.ОЮУНСҮРЭН



# “ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2013 оны 04 сарын 27 өдөр

№: 06

Улаанбаатар хот

## ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76.1.16 заалт, “Орхон булаг” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн 2013 оны 3-р сарын 11 өдрийн “Их хэмжээний хэлцлийг батлах тухай” Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 03дугаар тогтоолыг үндэслэн их хэмжээний хэлцэл хийх эрхийг компанийн Гүйцэтгэх Захирал /А.Лайханжав/-д олгосугай.
2. Их хэмжээний хэлцэлээр худалдах хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн үнийг хавсралтаар баталсугай.
3. Их хэмжээний хэлцэл хийсэн тухай дүнг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх Захирал /А.Лайханжав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ОЮУНСҮРЭН

**“ОРХОН БУЛАГ” ХК – ИЙН ХУВЬЦАА**  
**ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2013 оны 04 сарын 27 өдөр

№: 07

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫГ БАТЛАХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.1 дэх заалт, 2013 оны 4-р сарын 27 – ний өдрийн тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Орхон булаг” ХК-г ХХК болгон өөрчилхөөр шийдвэрлэсэн тул “Орхон булаг” ХХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга болон компанийн улсын бүртгэлд орсон өөрчлөлтүүдийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Д.ОЮУНСҮРЭН

